



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 53

Улаанбаатар хот

Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн  
түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2, 28 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, Засгийн газрын 2001 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслүүлэх журам”-ын 10 дахь заалтыг тус тус үндэслэн төрийн өөрийн өмчийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, түрээслэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг нээлттэй, ил тод зохион байгуулах зорилгоор ТОГТООХ нь:

1.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, материалыг үнэлэх, дүгнэх үүрэг бүхий комиссыг дарга, нарийн бичиг, гишүүдийн 5-аас дээшгүй хүний бүрэлдэхүүнтэй дор дурдсанаар байгуулсугай:

1.1.Төрийн өөрийн өмчийн 60 м.кв-аас дээш талбайг түрээслүүлэхэд Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын тушаалаар комисс байгуулна. Комисст түрээслүүлэгчийн 2 төлөөллийг оруулна.

1.2.Төрийн өөрийн өмчийн 60 м.кв хүртэл талбай болон бусад эд хөрөнгийг түрээслүүлэхэд түрээслүүлэгч хуулийн этгээдийн удирдлагын тушаалаар комисс байгуулна. Комисст Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2 хүртэл төлөөллийг оруулна.

2.Түрээслэгчийг сонгон шалгаруулах зарын маягтыг 1 дүгээр хавсралтаар, сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, нээх, дүгнэх аргачлалыг 2 дугаар хавсралтаар, сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх маягтыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчийг сонгон шалгаруулахад энэхүү тогтоолыг мөрдөж ажиллахыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан Төрийн өмчийн хорооны 2009 оны “Журам батлах тухай” 371 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

5.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА


ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН  
ХЭЛТСИЙН ДАРГА



Ц.НЯМ-ОСОР

Б.ГАВАА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2017 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн  
 ..... дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



**ТҮРЭЭСЛЭГЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЫН МАЯГТ**

**1.Түрээслүүлэх эд хөрөнгийн танилцуулга**

.....  
 .....  
 .....  
 .....  
 .....  
 .....

..... (эд хөрөнгийг түрээслүүлэх зориулалт, түрээслүүлэх талбайн хэмжээ, хаяг байршил болон бусад шаардлагатай мэдээллийг тусгана.)

**2.Сонгон шалгаруулалтын ерөнхий мэдээлэл**

Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах эцсийн хугацаа	20..... оны ..... дугаар сарын ..... -ны өдрийн ..... цагт  /сонгон шалгаруулалтыг зарласнаас хойш 15-аас багагүй хоногоор тогтоох/
Материал хүлээн авах хаяг	.....
Материал нээх хугацаа, хаяг байршил	..... /материал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш 1 цагийн дотор, оролцогчдын өмнө нээх/
Эд хөрөнгө түрээслүүлэх үнийн доод хэмжээ	.....  (..... үсгээр) төгрөг
Түрээслэгч үйл ажиллагаа эрхлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрлийн мэдээлэл	..... ..... ..... /шаардлагатай тусгай зөвшөөрлийн талаарх мэдээллийг бүрэн тусгах/
Түрээслэгчийг сонгон шалгаруулах тухай ерөнхий мэдээлэл	..... ..... ..... /шаардлагатай мэдээллийг тусгах/

<p>Оролцогчдын бүрдүүлж ирүүлэх материал</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ (иргэний хувьд цахим үнэмлэх), эрх бүхий байгууллагаас олгосон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тус тус нотариатаар баталгаажуулсан хуулбар;</li> <li>• Үйл ажиллагааны танилцуулга, ажлын туршлагын талаарх мэдээлэл (өмнө нь хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлыг бичих);</li> <li>• Санхүүгийн чадварыг нотлох баримт (иргэн, хуулийн этгээдийн харилцагч банкны баталгаажуулсан дансны тодорхойлолт);</li> <li>• Ажиллах хүчний мэдээлэл, мэргэжлийн диплом, үнэмлэхний нотариатаар баталгаажуулсан хуулбар;</li> <li>• Шаардлагатай тохиолдолд худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны чиглэлийн технологийн баримт бичиг;</li> <li>• Талбай болон үндсэн хөрөнгө түрээслэх үнийн санал</li> </ul> <p>.....</p> <p>/Түрээслүүлэх эд хөрөнгийн нөхцөл байдал, онцлогоос хамааран түрээслүүлэгч нь нэмэлт материал шаардаж болох бөгөөд зард заавал тусгах/</p>
--	--


### 3.Түрээслүүлэх хөрөнгийн талаар мэдээлэл авах

Түрээслүүлэх хөрөнгийг өмч эзэмшигч ..... байгууллага дээр очиж үзэж болох бөгөөд сонгон шалгаруулалтын заавар, бүртгэх хугацаа, хөрөнгийн талаарх мэдээллийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын ..... утсаар болон цахим хуудаснаас авна уу.

Хаяг:

Холбогдох утасны дугаар:

Жич: Түрээслэгчийг сонгон шалгаруулах зарыг өдөр тутмын сонин болон байгууллагын цахим хуудсанд тавина.



## СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ, НЭЭХ, ДҮГНЭХ АРГАЧЛАЛ

### **Сонгон шалгаруулалтын материал ирүүлэх:**

- Оролцогч нь сонгон шалгаруулалтын материалыг тогтоосон хугацаанд, бүрэн бүрдүүлж ирүүлнэ. Бүрдүүлсэн материалыг битүүмжилж материалын жагсаалтыг дугуйны гадна талд бичсэн байна.
- Оролцогч нь дурдсан хаягаар, хэлбэрээр заасан материалаа өөрийн биеэр эсхүл итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтанд хүлээлгэн өгнө.
- Оролцогч нь сонгон шалгаруулалтыг нээхээс өмнө татгалзах саналаа ирүүлж болно.
- Сонгон шалгаруулалтад ирүүлсэн материалын үнэн зөвийг оролцогч бүрэн хариуцна.

### **Сонгон шалгаруулалтын материал хүлээн авах, нээх:**

- Түрээслүүлэгчийн бичиг хэргийн ажилтан сонгон шалгаруулалтын зард заасан хугацаанд ирүүлсэн материалыг бүртгэж, хүлээн авна. Бичиг хэргийн ажилтан битүүмжлээгүй, хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
- Бичиг хэргийн ажилтан сонгон шалгаруулалтын материалыг бүртгэлийн хамт комиссын нарийн бичигт хүлээлгэн өгнө.
- Комисс нь сонгон шалгаруулалтын материалыг нээж, бүрдлийг шалган тэмдэглэл үйлдэнэ.
- Сонгон шалгаруулалтын материалын бүрдэл дутуу тохиолдолд оролцогчийг үл маргах журмаар хасна.

### **Сонгон шалгаруулалтын материалыг дүгнэх:**

- Комисс хуралдах бүр тэмдэглэл хөтөлж зохих ёсоор баталгаажуулна.

- Комиссын гишүүн бүр сонгон шалгаруулалтын материалтай танилцсаны үндсэн дээр маягтын дагуу дүгнэнэ.

- Материалыг бүрэн ирүүлсэн, тавигдах шаардлагыг хангасан, сонгон шалгаруулалтын комиссын нийт гишүүдийн дүнгийн нийлбэрээр хамгийн өндөр оноо авсан оролцогчийг төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээслэгчээр сонгон шалгаруулна.


омиссын нарийн бичиг хурлын тэмдэглэл хөтөлж баталгаажуулах, гишүүдийн онооны хуудсыг нэгтгэх, оролцогчдын материалыг хадгалах, зохих заавар журмын дагуу архивт шилжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

- Сонгон шалгаруулалтын комисс материал нээснээс хойш ажлын 10 өдрийн дотор энэхүү тогтоолд заасны дагуу дүгнэсэн байна.

- Сонгон шалгаруулалтын комисс хамгийн өндөр оноо авсан оролцогчид мэдэгдэл, бусад оролцогчид үндэслэл бүхий хариу хүргүүлнэ.

- Мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 5-аас багагүй өдрийн дараа түрээсийн гэрээг холбогдох заавар, захиргааны актын дагуу байгуулна.

- Оролцогч нарт хариу мэдэгдэл хүргүүлснээс хойш ажлын 3 өдрийн дотор комисс нь сонгон шалгаруулалтын тайлан (оролцогчдын материал, гишүүдийн дүгнэсэн маягт, хурлын тэмдэглэл, мэдэгдэл, үндэслэл бүхий хариу бичиг)-г Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.



**СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛЫГ  
ДҮГНЭХ МАЯГТ**

.. оны ... сарын ..... өдөр

Улаанбаатар хот

Д/д	Сонгон шалгаруулалтад оролцогчийн нэр	Шалгуур үзүүлэлт /нийт 100 оноо/					Нийт оноо
		Материалын бүрдэл /15 оноо/	Туршлага /15 оноо/	Ажиллах хүчний чадвар /20 оноо/	Санхүүгийн чадвар /25 оноо/	Үнийн санал /25 оноо/	
1							
2							
3							

Жич:

- Оролцогчийн эрхлэх үйл ажиллагаа нь түрээслүүлэх эд хөрөнгийн зориулалтад нийцсэн байх;
- Үйл ажиллагааны чиглэлээр эрх бүхий, мэргэшсэн, туршлагатай байх;
- Түрээсийн төлбөр болон барьцааг (3 сарын түрээсийн төлбөртэй тэнцэх хэмжээний) төлөх санхүүгийн чадвартай, хөрөнгийн баталгаатай байх.

Дүгнэсэн:

Комиссын дарга, нарийн бичиг, гишүүн /алин болохыг тэмдэглэх/

Гарын үсэг .....

гарын үсгийн тайлал.....